












АГУУЛГА

	Хуудасны дугаар
 НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	2
 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	4
 АЖ ҮЙЛДВЭР	13
 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	16
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	17
 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	18
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	20
 ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ	24
 ГЭМТ ХЭРЭГ	25
 ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	27
 НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ	29

Хүснэгт 1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн 11 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Бэлэн хүн ам, сарын эцэст	мянган хүн	1241.9 ^{↑3.6}	1268.5 ^{↑2.1}	1312.7 ^{↑3.5}	1358.7 ^{↑3.5}	1380.6 ^{↑1.6}
Шинээр төрсөн хүүхэд	тоо	33853 ^{↑9.3}	36714 ^{↑8.5}	38291 ^{↑4.3}	38253 ^{↓0.1}	37466 ^{↓2.1}
Ажилгүйчүүд, сарын эцэст	мянган хүн	14.0 ^{↓-58.8}	15.2 ^{↑8.6}	15.6 ^{↑2.6}	11.8 ^{↓24.4}	11.8 ^{=0.0}
үүнээс : эмэгтэй	мянган хүн	7.9 ^{↓-47.0}	8.6 ^{↑8.9}	8.8 ^{↑2.3}	6.6 ^{↓25.0}	6.0 ^{↓8.8}
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	22590 ^{↑37.6}	16813 ^{↓25.6}	16381 ^{↓2.6}	37533 ^{↑129.1}	37594 ^{↑0.2}
Бүртгэсэн гэмт хэрэг	тоо	11584 ^{↑16.8}	14024 ^{↑21.1}	15579 ^{↑11.1}	16445 ^{↑5.6}	16689 ^{↑1.5}
Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	хувь	-0.2 ^{↓-0.9}	1.3 ^{↑1.5}	0.6 ^{↓-0.7}	0.6 =	0.7 ^{0.1}
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$ =₮	1397 ^{↑4.2}	1742 ^{↑24.7}	1895 ^{↑8.8}	1995 ^{↑5.3}	2467 ^{↑23.6}
Нийслэлийн төсвийн орлого	тэрбум төгрөг	368.9 ^{↑74.4}	613.9 ^{↑66.4}	705.1 ^{↑14.9}	718.5 ^{↑1.9}	767.8 ^{↑6.9}
Нийслэлийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	205.3 ^{↑57.6}	526.2 ^{↑156.3}	609.9 ^{↑15.9}	752.0 ^{↑23.3}	899.6 ^{↑19.6}

Тайлбар: өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтийн хувь


↑, ↓ эерэг
 ↑, ↓ сөрөг
 = тогвортой

Хүснэгт 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

	Хэмжих Нэгж	2015 оны 11 сарын байдлаар				2016 оны 11 сарын байдлаар					
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	287	Баянгол	7253	Налайх	52	293	Баянгол	7155	Налайх	53
			Чингэлтэй	1834	Багануур	47		Чингэлтэй	1779	Багануур	47
			Сүхбаатар	672	Багахангай	29		Сүхбаатар	674	Багахангай	30
Ажилгүйчүүд хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	0\000**	136	Багахангай	473	Баянгол	95	139	Багахангай	501	Сонгинохайрхан	113
			Налайх	434	Сонгинохайрхан	87		Налайх	414	Баянгол	111
			Багануур	283	Баянзүрх	80		Багануур	287	Баянзүрх	107
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	14	Багахангай	15	Багануур	10	15	Налайх	22	Хан-Уул	9
			Налайх	14	Баянгол	9		Багануур	21	Баянгол	9
			Сонгинохайрхан	13	Хан-Уул	9		Баянзүрх	15	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	291	Баянзүрх	319	Хан-Уул	224	283	Баянзүрх	325	Сүхбаатар	228
			Чингэлтэй	263	Багануур	191		Багануур	270	Хан-Уул	222
			Сонгинохайрхан	258	Багахангай	83		Чингэлтэй	256	Багахангай	65
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	мян.төг	96	Сүхбаатар	119	Багануур	83	96	Чингэлтэй	114	Багануур	78
			Чингэлтэй	116	Налайх	76		Сүхбаатар	113	Налайх	75
			Хан-Уул	115	Багахангай	68		Хан-Уул	111	Багахангай	65
18-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	181	Сүхбаатар	293	Багануур	148	187	Сүхбаатар	292	Багануур	147
			Чингэлтэй	189	Хан-Уул	132		Баянгол	212	Сонгинохайрхан	132
			Баянгол	183	Багахангай	82		Чингэлтэй	212	Багахангай	79

Тайлбар: * - промилль


** - продицмилль



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2016 оны 11-р сарын хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 хувиар, 2015 оны жилийн эцэстэй харьцуулахад 0.4 хувиар тус тус буурч, харин өмнөх 10-р сартай харьцуулахад 0.7 хувиар өссөн байна.

Зураг 1. Хэрэглээний үнийн индекс, 2014-2016 он



Хэрэглээний үнийн индекс 2016 оны 11-р сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 0.4 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 1.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 2.8 хувь, тээврийн бүлгийн үнэ 1.7 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 1.8 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.

Хүснэгт 3. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2014-11</u> 2013-11	<u>2015-11</u> 2014-11	<u>2016-11</u> 2015-11	<u>2016-11</u> 2015-12	<u>2016-11</u> 2016-10
Ерөнхий индекс	111.9	101.9	99.4	99.6	100.7
Хүнсний бараа, ундаа, ус	108.1	94.0	98.3	98.5	99.4
Согтууруулах ундаа, тамхи	110.7	103.3	104.3	104.3	101.0
Хувцас, бөс бараа, гутал	112.5	102.6	98.9	98.7	100.6
Орон сууц, ус, цахилгаан, түлш	123.9	104.6	95.4	97.2	104.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	111.1	105.8	100.7	100.6	100.3
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	112.8	104.0	108.8	107.7	101.0
Тээвэр	110.1	100.9	98.3	98.3	100.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.7	99.3	100.6	100.6	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	109.4	100.8	98.5	98.2	100.4
Боловсролын үйлчилгээ	117.7	123.6	102.6	102.6	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	105.2	102.2	102.5	101.2	101.2
Бусад бараа, үйлчилгээ	110.2	106.0	101.3	100.9	100.3

2016 оны 11-р сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 329 нэрийн бараа, үйлчилгээний 27.0 хувийнх нь үнэ өсч, 21.0 хувийнх нь үнэ буурч, 52.0 хувийнх нь бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байлаа.

Хүснэгт 4. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекс
нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	-0.6	Энэ бүлгийн бүүралтад мах, махан бүтээгдэхүүн 3.1 хувиар, жимс, жимсгэнэ 0.8 хувиар, төмс, хүнсний ногоо 0.2 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи	1.0	Согтууруулах ундаа, тамхины бүлгийн өсөлт нь архи, спирт 0.4 хувь, дарс 1.1 хувь, тамхи 1.5 хувиар өссөнтэй холбоотой байна.
Хувцас, бөс бараа, гутал	0.6	Хувцас, бөс бараа, гутлын бүлгийн өсөлтөд жижиг эдлэл, хэрэгсэл 2.3 хувиар, бүх төрлийн хувцас 0.6 хувиар, бүх төрлийн гутал 0.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Орон сууц, ус, цахилгаан, түлш	4.0	Энэ бүлгийн өсөлтөд хатуу түлш 17.4 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.3	Энэ бүлгийн өсөлтөд цахилгаан хэрэгслийн засвар 9.4 хувиар, шилэн эдлэл, сав суулга 1.7 хувиар, гэр ахуйн бараа 1.4 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.0	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн өсөлт нь амбулаторын үйлчилгээ 10.4 хувиар, шүдний эмнэлгийн үйлчилгээ 3.0 хувиар, эмнэлгийн туслах үйлчилгээ 3.2 хувиар өссөнтэй холбоотой байв.
Тээвэр	0.4	Тээврийн үйлчилгээний өсөлтөд агаарын зорчигч тээврийн үйлчилгээ 6.6 хувиар өссөн нь нөлөөлөв.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.4	Энэ бүлгийн өсөлтөд тоглоом, наадам, хобби 3.2 хувиар, ном 0.6 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	1.2	Энэ бүлгийн өсөлтөд гуанз, цайны газрын хоолны үнэ 1.8 хувиар өссөнтэй холбоотой байна.
Бусад бараа, үйлчилгээ	0.3	Бусад бараа, үйлчилгээний өсөлт нь гоо сайхны хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлс 0.6 хувиар, хувь хүний бусад эд зүйл, хэрэглэл 1.6 хувиар өссөнтэй холбоотой байна.

Зураг 2. Нэг кг будааны дундаж үнэ, 2011-2016 оны 11-р сард, төгрөг




Зураг 3. Нэг кг дээд гурилын дундаж үнэ, 2011-2016 оны 11-р сард, төгрөг




2016 оны 11-р сард хүнсний зах, дэлгүүрт жижиглэн худалдаалах махны үнэ өмнөх сартай харьцуулахад хонины ястай мах 7.0 хувиар буурч, харин үхрийн ястай мах 5.0 хувиар өссөн байна. Өмнөх сартай харьцуулахад талх, гурил, будааны бүлгийн үнэ 0.4 хувиар өсч, харин төмс, хүнсний ногооны бүлгийн үнэ 0.2 хувиар буурчээ.

Зураг 4. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, 2011-2016 оны 11-р сард




Зураг 5. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, 2011-2016 оны 11-р сард



Зураг 6. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, 2011-2016 оны 11-р сард

Манжин




Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн мэдээ

Багануур дүүргийн түүхий

эдийн захын дундаж үнээр нас гүйцсэн адуу 400.0 мянган төгрөг, үхэр 650.0 мянган төгрөг, эр хонь 100.0 мянган төгрөг, эм хонь 70.0 мянган төгрөг, ямаа 35.0-55.0 мянган төгрөгийн ханштай байв.

Зураг 7. Нэг ширхэг өндөгний дундаж үнэ, 2011-2016 оны 11-р сард




2016 оны 11-р сарын 29-ны өдрийн үнийн ажиглалтаар “Хүчит шонхор” зах дээр нэг кг тэмээний мах 2800 төгрөг, “Далай ээж” зах дээр гахайн мах 6000 төгрөг, тахианы мах 5500 төгрөг, өндөг 280 төгрөгийн ханштай байв.

Хүснэгт 5. Нэг кг махны жижиглэн худалдах дундаж үнэ, 2013-2016 оны сараар, төгрөгөөр


Үхрийн мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013 он	7335	8025	7895	8330	8380	8275	8225	7710	7825	7245	7115	7280
2014 он	7980	7775	8425	8370	8685	8730	7955	7590	7635	7550	7495	7465
2015 он	7415	7565	7810	8080	8145	8445	7985	7230	7005	5975	5620	5520
2016 он	6165	6875	7105	8170	8495	7930	6950	6865	6120	5235	5495	

Хонины мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013 он	6480	7095	7060	7420	7490	7470	7415	6710	6540	6215	6085	6245
2014 он	6855	6675	7040	7630	7800	7685	7030	6585	6395	5965	5835	5940
2015 он	5860	6140	6735	7460	7555	7455	6830	6050	5540	4510	4200	3930
2016 он	4625	5495	5970	6935	6945	6525	5780	5605	4940	4250	3945	

Зураг 8. Нэг кг хонины махны дундаж үнэ 2016 оны 11-р сард



Зураг 9. Нэг кг үхрийн махны дундаж үнэ 2016 оны 11-р сард




Хүснэгт 6. Арьс ширний дундаж үнэ, төгрөгөөр 2012 – 2014 онуудад


	2013 он		2014 он		2015 он		2016 он	
	X сар	XI сар	X сар	XI сар	X сар	XI сар	X сар	XI сар
Тэмээний шир	18000	20000	18000	20500	21500	23500	16500	17500
Адууны шир	35000	33000	32000	36000	35500	41333	29000	29667
Үхрийн шир	45000	48000	60000	62000	47667	41667	31667	32000
Хонины арьс	8000	8000	5000	4500	1500	1500	2500	2000
Ямааны арьс /ноолууртай/	13000	23000	10000	18000	8333	11667	9750	18500
Ямааны ноолуур	70000	74000	65000	65000	51000	-	45000	45000

Улаанбаатар хотын түүхий эдийн захуудын сарын дундаж үнээр тэмээний шир 17500 төгрөг, адууны шир 29667 төгрөг, үхрийн шир 1.8-2.3 метр урттай бол 17000 төгрөг, 2.3 метрээс дээш урттай нь 32000 төгрөг, хонины арьс 2000 төгрөг, ямааны ноолууртай арьс 18500 төгрөг, ямааны ноолуур 45000 төгрөгийн ханштай байлаа.

Зураг 10. Ямааны ноолуурын дундаж үнэ, төгрөгөөр



Зураг 11. Шатахууны үнэ, өөрчлөлт орсон өдрөөр




Хүснэгт 7. Түлшний үнэ, төгрөг

	2014.11.26		2015.11.25			2016.11.30	
	Түлшний хар мод шуудай (6-7 кг)	Нүүрс (Налайх) (12-14 кг)	Түлшний мод шуудай (6-7 кг)		Нүүрс (Налайх) (12-14 кг)	Түлшний хар мод шуудай (6-7 кг)	Нүүрс (Налайх) (12-14 кг)
			Хар мод	Нарс мод			
Чингэлтэй	1600	2800	1800		3000	1800	2000
Сүхбаатар	1500	3000	1800		3000	2000	2200
Цайз зах	1500	2500	1700		3000	1800	2000
Хангай зах	1500	3000	1800	1500	3000	1800	2000
Дундаж	1525	2825	1775	1500	3000	1850	2050

Хүснэгт 8. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2015.11.25					2016.11.30				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	1890	1550	1660	1790		1730		1530	1640	
Петровис	1890	1550	1660	1790		1730	1450	1530	1640	
Магнай трейд	1890	1550	1660	1790		1730	1450	1530	1640	
Сод монгол	1890		1660	1790		1730		1550	1640	
Шунхлай		1550	1660	1790			1450	1530	1640	
Юнигаз					1100					900
Дундаж үнэ	1890	1550	1660	1790	1100	1730	1450	1534	1640	900

Зураг 12. Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш, 2013-2016 он



Мэдээлийн эх сурвалж: Монголбанкны статистикийн мэдээлэл

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2016 оны 11-р сарын танилцуулга


Хүснэгт 10. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2011-2016 оны 11-р сарын V долоо хоногоор

		хэмжих нэгж	2011.11	2012.11	2013.11	2014.11	2015.11	16.11.30	2016/2015	2016/2014	2016/2013	2016/2012	2016/2011
"Алтан тариа" гурил	дээд	кг	845	827	1053	1180	1265	1270	100.4	107.6	120.6	153.6	150.3
	1-р зэрэг	кг	696	703	752	1005	1065	1065	100.0	106.0	141.6	151.5	153.0
"Алтан тариа" савласан гурил	дээдийн дээд	кг	1044	1103	1468	1625	1595	1585	99.4	97.5	108.0	143.7	151.8
	дээд	кг	901	904	1084	1225	1295	1305	100.8	106.5	120.4	144.4	144.8
	1-р зэрэг	кг	747	783	774	1035	1095	1095	100.0	105.8	141.5	139.8	146.6
	2-р зэрэг	кг	580	594	591	830	835	825	98.8	99.4	139.6	138.9	142.2
"Алейка" дээд гурил		кг	905	977	1356	1335	1310	1305	99.6	97.8	96.2	133.6	144.2
Сүү	Сүү ХК 1л	литр			2000	2435	2125	2165	101.9	88.9	108.3		
	Сүү ХК 0.5л	литр		625	863	1180	900	935	103.9	79.2	108.3	149.6	
	Задгай	литр	1200	1160	1450	1400	1235	1250	101.2	89.3	86.2	107.8	104.2
Тараг, Цөцгийтэй		литр		1597	1980	2155	2130	2085	97.9	96.8	105.3	130.6	
Талх	Атар	ширхэг	650	658	839	1065	1150	1160	100.9	108.9	138.3	176.3	178.5
	Зууван чех	ширхэг		924	928	1180	1255	1215	96.8	103.0	130.9	131.5	
Будаа	цагаан	кг	1655	1738	2263	2365	2510	2605	103.8	110.1	115.1	149.9	157.4
	шар	кг	1614	1635	1560	1810	1695	1730	102.1	95.6	110.9	105.8	107.2
Цөцгийн тос, "Сүү" ХК		кг		2210	2244	2625	3255	3255	100.0	124.0	145.1	147.3	
Ургамлын тос		1 литр		2696	3114	3115	3425	3355	98.0	107.7	107.7	124.4	
Ногоон цай, Гүрж		кг		3820	4504	5075	5555	5735	103.2	113.0	127.3	150.1	
Элсэн чихэр		кг	1667	1733	1667	1730	1785	2315	129.7	133.8	138.9	133.6	138.9
Хонины мах	ястай*	кг			5945	6050	3920	3860	98.5	63.8	64.9		
	цул	кг	4317	6440	6780	7230	5015	5045	100.6	69.8	74.4	78.3	116.9
Үхрийн мах	ястай*	кг			6980	7465	5520	5575	101.0	74.7	79.9		
	цул*	кг			8540	9395	7065	7215	102.1	76.8	84.5		
Адууны мах, ястай*		кг			5395	5435	4530	4405	97.2	81.0	81.6		
Ямааны мах, ястай*		кг			4805	4810	3280	3355	102.3	69.8	69.8		
Төмс, монгол		кг	978	969	815	970	1080	735	68.1	75.8	90.2	75.9	75.2
Лууван, монгол		кг	935	1140	1278	1200	1640	915	55.8	76.3	71.6	80.3	97.9
Байцаа, монгол		кг	955	967	1250	1100	1470	800	54.4	72.7	64.0	82.7	83.8
Манжин, монгол		кг	957	1044	1622	1210	1810	1380	76.2	114.0	85.1	132.2	144.2
Сонгино, хятад бөөрөнхий		кг	994	1074	1290	1170	1285	1255	97.7	107.3	97.3	116.9	126.3
Алим, фүжи		кг		3779	3570	4035	3920	4170	106.4	103.3	116.8	110.3	
Өндөг, ОХУ		ширхэг	253	269	401	325	290	270	93.1	83.1	67.3	100.4	106.7

Хүснэгт 11. Хүнсний барааны үнийн зэрэгцүүлэлт, 2016 оны 11-р сарын 30-ны өдрийн байдлаар

		хэмжих нэгж	"Баянзүрх" зах	"Сансар" Супер-маркет	"Хүчит шонхор" зах	"Бөмбөгөр" ХТ	"Меркури" зах	"Барс" ХТ	"Таван эрдэнэ" зах	"Хархорин" зах	"Номин" Супер-маркет	"Макс" Супер-маркет	"Оргил" Супер-маркет	дундаж үнэ
"Алтан тариа" гурил	дээд	кг	1300	1299	1300	1150		1200	1300	1300	1264	1332	1243	1270
	1-р зэрэг	кг	1100	1050	1100	1000		1000	1100	1100	1049	1068		1065
"Алтан тариа" савласан гурил	дээдийн дээд	кг	1600	1610	1600	1500	1800	1500	1500	1550	1579	1660	1540	1585
	дээд	кг	1300	1330	1300	1200	1500	1200	1300	1300	1289	1360	1290	1305
	1-р зэрэг	кг	1100	1090	1100	1000	1300	1000	1100	1100	1049	1100	1088	1095
	2-р зэрэг	кг	850		800	800		800	900	800			830	825
"Алейка" дээд гурил		кг	1300	1260	1200	1300	1500	1200	1300	1300	1379	1370	1270	1305
Сүү	Сүү ХК 1л	литр	2100	2240	2300	2100	2200	2100	2300	2100	2149	2110	2100	2165
	Сүү ХК 0.5л	литр	950	940	950	950	1000	900	1000	950	899	890	880	935
	Задгай	литр			1000				1100	1200	1699			1250
Тараг, Цөцгийтэй		литр	2100	2040	2000	2000	2200	2000	2300	2100	2149	1950	2110	2085
Талх	Атар	ширхэг	1200	1210	1200	1100		1100	1200	1100	1209	1170	1100	1160
	Зууван чех	ширхэг	1300	1270	1300	1150		1150	1250	1150	1169	1200	1200	1215
Будаа	цагаан	кг	2300	3260	2400	2200		2300	2300	2400	3249	2580	3060	2605
	шар	кг	1600	2100	1500	1500		1300	1900	1800		2140		1730
Цөцгийн тос, "Сүү" ХК		кг	3200	3300	3000	3500	3500	3000	3500	3200	3279	3220	3080	3255
Ургамлын тос		1 литр	3200	3570	3200	3100	3500	3300	3300	3200	3529	3540	3470	3355
Ногоон цай, Гүрж		кг	5500	6410	5500	5200		5000	5850	5500	6299	6360		5735
Элсэн чихэр		кг	2200	2500	2000	2200	2500	2100	2300	2000		3000	2370	2315
Хонины мах	ястай*	кг	3900	4000	3700	4800	5500	4600	5300	3600	4399	3700		3860
	цул	кг	4500		4500	5300		5500	6500	4200		4800		5045
Үхрийн мах	ястай*	кг	5400	5800	5500	6500	7500	6000	6500	5300	6199	4800		5575
	цул*	кг	6800		7000	7000	9000	7000	7500	7000	7499	6500		7215
Адууны мах, ястай*		кг	4500		4400	5000				4300				4405
Ямааны мах, ястай*		кг	3500		3400	4000				3200				3355
Төмс, монгол		кг	800	690	500	700	800	600	900	600	499	800	1200	735
Лууван, монгол		кг	800	1160	800	800	1000	800	1000	800	699	1000	1200	915
Байцаа, монгол		кг	800	750	800	700	1000	700	800	800	599	650	1200	800
Манжин, монгол		кг	1500		1300	1500	1500	1200	1200	1200	999	1600	1800	1380
Сонгино, хятад бөөрөнхий		кг	1500	1050	1000	1300	1500	1000	1200	1100	1199	1450	1500	1255
Алим, фүжи		кг	3500		3500	4500	4000	3500	4500	4000	4899	4800	4500	4170
Өндөг, ОХУ		ширхэг	250	260	250	230	300	250	300	250	279	300	280	270


Тайлбар: * Махны дундаж үнийг хүнсний захуудын махны борлуулалтын хувийн жинд үндэслэн жигнэсэн дундаж аргаар тооцов.



АЖ ҮЙЛДВЭР

Нийслэлийн аж үйлдвэрийн газрууд 2016 оны эхний 11 сард 6196.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 6893.0 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 14.1 хувиар, борлуулалт 5.3 хувиар өссөн байна.


Зураг 13. АҮ-ийн 2015-2016 оны үйлдвэрлэлт, борлуулалт /Тэрбум. төг/




Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэлт 14.9 хувиар, уул уурхайн олборлох үйлдвэрлэлт 19.5 хувиар, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 7.4 хувиар, боловсруулах үйлдвэрлэлт 0.6 хувиар тус тус өссөн байна.

Нийслэлийн аж үйлдвэрийн салбар 2016 оны 11-р сард 694.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхайн олборлох салбар 66.9 хувийг, цахилгаан дулааны эрчим хүч усан хангамжийн үйлдвэрлэлт 10.2 хувийг, боловсруулах үйлдвэрлэлт 22.9 хувийг тус тус эзэлж байна.


Зураг 14. Махны үйлдвэрлэлт, мян.тн




Зураг 15. Гурил үйлдвэрлэлт, мян.тн



Зураг 16. Талх, архи дарсны үйлдвэрлэлт



Зураг 17. Нүүрс олборлолт, мян.тн




Хүснэгт 12. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/


Салбараар	Нийт бүтээгдэхүүн		
	2015 он XI сар	2016 он XI сар	$\frac{2016}{2015}$ %
Уул уурхай олборлох үйлдвэр	3412956.7	4077752.3	119.5
Нүүрс олборлолт	283114.6	415498.3	146.8
Газрын тос, шатдаг хий олборлолт	761574.1	661475.8	86.9
Төмрийн хүдэр олборлолт	2302985.9	2941799.7	127.7
Бусад ашигт малтмал олборлолт	65282.1	58978.5	90.3
Боловсруулах үйлдвэр	1412917.5	1421732.3	100.6
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	739254.0	794160.4	107.4
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	69681.1	62119.3	89.1
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	45640.7	55966.5	122.6
Үр тарианы гурил, малын тэжээл	113392.1	121829.6	107.4
Хүнсний бусад бүтээгдэхүүн	87486.6	93209.4	106.5
Ундаа үйлдвэрлэл	423053.5	461035.6	109.0
Тамхи үйлдвэрлэл	63746.0	17415.5	27.3
Нэхмэлийн үйлдвэрлэлт	258792.5	358812.7	138.6
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	9736.6	8939.7	91.8
Арьс шир боловсруулах үйлдвэр	16201.6	9341.0	57.7
Мод модон эдлэл үйлдвэрлэл	2863.9	4278.8	149.4
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7480.3	7700.0	102.9
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	23439.5	24309.3	103.7
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	41549.4	42288.6	101.8
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	33217.3	19764.9	59.5
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	35395.6	32017.0	90.5
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	1047.6	959.1	91.6
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	2608.0	2518.2	96.6
Мебель тавилга үйлдвэрлэл, бусад үйлдвэрлэл	177585.2	99227.1	55.9
Цахилгаан, дулаан, усан хангамж	606895.1	697280.2	114.9
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	566330.5	656644.4	115.9
Ус ариутгал, усан хангамж	40564.6	40635.8	100.2
ДҮН	5432769.3	6196764.8	114.1

*дахин

Зураг 18. Үйлдвэрлэлт, 2014-2016 он, тэрбум төг



Зураг 19. Борлуулалт, 2014-2016 он тэрбум төг



Хүснэгт 13. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2015 он XI сар	2016 он XI сар	$\frac{2016}{2015}$ %	Үүнээс: экспорт, %
Уул уурхай олборлох үйлдвэр	4525815.5	4675685.4	103.3	71.2
Нүүрс олборлолт	216650.6	404908.0	186.9	71.3
Газрын тос, шатдаг хий олборлолт	721723.8	643691.3	89.2	100.0
Төмрийн хүдэр олборлолт	3534957.6	3572490.9	101.1	66.1
Бусад ашигт малтмал олборлолт	52483.5	54595.2	104.0	66.4
Боловсруулах үйлдвэр	1410874.2	1520064.0	107.7	24.6
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	819344.1	846924.7	103.4	1.6
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	128717.8	72463.0	56.3	14.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	45805.4	61662.7	134.6	
Үр тарианы гурил, малын тэжээл	115778.8	123475.8	106.6	1.5
Хүнсний бусад бүтээгдэхүүн	87273.6	95829.3	109.8	
Ундаа үйлдвэрлэл	441768.5	493493.9	111.7	0.3
Тамхи үйлдвэрлэл	63583.0	70646.1	111.1	5.0
Нэхмэлийн үйлдвэрлэлт	218696.9	309329.9	141.4	75.3
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	10294.5	10581.3	102.8	
Арьс шир боловсруулах үйлдвэр	15330.4	9315.3	60.8	70.0
Мод модон эдлэл үйлдвэрлэл	2756.0	5148.8	186.8	
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7330.9	7733.8	105.5	
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	24440.3	26818.2	109.7	
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	41740.3	47861.9	114.7	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	35398.9	19771.3	55.9	
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	35673.2	34741.4	97.4	
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	1004.1	1012.4	100.8	
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	2522.5	2615.4	103.7	
Мебель тавилга үйлдвэрлэл, бусад үйлдвэрлэл	132759.1	127563.5	96.1	92.1
Цахилгаан, дулаан, усан хангамж	606895.1	697280.2	114.9	
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	566330.5	656644.4	115.9	
Ус ариутгал, усан хангамж	40564.6	40635.8	100.2	
ДҮН	6543584.8	6893029.6	105.3	53.8

Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 3187.5 тэрбум төгрөгийг дотоодод, 3705.5 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна.

2016 оны эхний 11 сард борлуулсан нийт бүтээгдэхүүний 53.8 хувийг экспортоор гаргасан байна. Нийт экспортын 7.8 хувийг нүүрс олборлолт, 17.4 хувийг газрын тос шатдаг хий олборлолт, 63.8 хувийг төмрийн хүдэр олборлолт, 1.0 хувийг бусад ашигт малтмал олборлолт, 6.3 хувийг нэхмэлийн үйлдвэрлэлт, 0.2 хувийг арьс шир боловсруулах үйлдвэрлэлт, 0.3 хувийг хүнсний үйлдвэрлэлт, тамхи болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 3.2 хувийг тус тус эзэлж байна.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны эхний 11 сард нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 26.1 мянган байгууллагын 604.6 мянган иргэд хамрагдаж нийгмийн даатгалын шимтгэл төлжээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийт иргэдийн 399.4 мянга буюу 66.1 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын, 113.0 мянга буюу 18.7 хувь нь төсөвт байгууллагын, 92.9 мянга буюу 15.2 хувь нь сайн дурын даатгуулагчид байна.

Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар буюу 72.9 мянган хүнээр буурчээ.


Зураг 20. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагууд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 101.5 хувиар биелүүлж, нийгмийн даатгалын санд нийт 719.6 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 62.7 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 20.0 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 7.1 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.5 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 1.7 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 21. Даатгалын сангийн зарлага



Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас энэ оны эхний 11 сард даатгуулагч, иргэдэд 902.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгожээ.

Нийт зардлын 69.5 хувийг тэтгэврийн, 15.1 хувийг эрүүл мэндийн, 6.6 хувийг ҮОМШӨ-ний, 6.6 хувийг тэтгэмжийн, 2.3 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 11 дугаар сард 151.9 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 539.7 тэрбум төгрөгт хүрчээ.

Олгосон нийт тэтгэврийн 75.4 хувийг өндөр насны, 10.0 хувийг хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн, 3.4 хувийг тэжээгчээ алдсаны, 11.2 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2016 оны 11 дугаар сарын эцэст 11817 болж, өмнөх оны мөн үеэс 0.5 хувь буюу 63 хүнээр өсчээ. Нийт ажилгүйчүүдийн 6040 буюу 51.1 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 22. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 14.5 хувь буюу 1711 нь 15-24 насны, 39.4 хувь буюу 4658 нь 25-34 насны, 25.1 хувь буюу 2970 нь 35-44 насны, 21.0 хувь буюу 2478 нь 45-аас дээш насны хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 18.6 хувь буюу 2198 нь Баянзүрх, 18.5 хувь буюу 2189 нь Сонгинохайрхан, 13.5 хувь буюу 1596 нь Чингэлтэй, 12.3 хувь буюу 1457 нь Хан-Уул, 12.3 хувь буюу 1449 нь Баянгол, 11.7 хувь буюу 1383 нь Сүхбаатар, 7.7 хувь буюу 907 нь Налайх, 4.3 хувь буюу 511 нь Багануур, 1.1 хувь буюу 127 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

2016 оны 11-р сард ажилгүй 3947 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 799 иргэн ажилд зуучлагдан орж, 2696 иргэн бүртгэлээс хасагджээ.

Хүснэгт 14. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /12-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2014 он	2015 он	2016 он	2014 он	2015 он	2016 он
Нийт ажилгүйчүүд	15560	11754	11817	100	100	100
Үүнээс: дээд боловсролтой	6235	4197	5063	40.1	35.7	42.9
Тусгай дүнд боловсролтой	1031	769	749	6.6	6.6	6.3
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	798	586	588	5.1	5.0	5.0
Ерөнхий боловсролтой	7411	6140	5365	47.6	52.2	45.4
Мэргэжилгүй	85	62	52	0.6	0.5	0.4

2016 оны эхний 11 сард 40861 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 5.2 хувь буюу 2249 хүнээр бүүрчээ.

2016 оны эхний 11 сард 8088 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 0.4 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 11.3 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 88.3 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны эхний 11 сард 37466 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 787 хүүхдээр цөөн байна.

Нийт төрсөн хүүхдийн 13.1 хувь буюу 4903 нь бусад аймгийн харъяат эхчүүдээс төрсөн байна.


Хүснэгт 15. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, эхний 11 сард

	2013 он	2014 он	2015 он	2016 он	$\frac{2016}{2015}$ %
Амаржсан эхийн тоо	36465	37963	37993	37230	98.0
Амьд төрсөн хүүхэд	36714	38291	38253	37466	97.9
Эхийн эндэгдэл	19	15	12	15	125.0
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	477	551	543	563	103.7
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	12.99	14.4	14.2	15.0	105.6

Нялхсын эндэгдлийн 28.9 хувь буюу 114 нь Баянзүрх, 21.5 хувь буюу 85 нь Сонгинохайрхан, 11.4 хувь буюу 45 нь Чингэлтэй, 10.9 хувь буюу 43 нь Баянгол, 10.1 хувь буюу 40 нь Сүхбаатар, 9.6 хувь буюу 38 нь Хан-Уул, 4.3 хувь буюу 17 нь Налайх, 3.3 хувь буюу 13 нь Багануур дүүрэгт тус тус гарсан байна.

Нялхсын эндэгдлийн 29.3 хувь буюу 165 нь бусад аймгийн харъяат байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 0.9 промилээр өсчээ.

Зураг 23. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар




Нийслэлд 2016 оны эхний 11 сард 37594 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар буюу 61 хүнээр өсч, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 8.1 промилээр буурчээ.

Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 42.5 хувийг улаан бурхан, 11.9 хувийг гар хөл амны өвчин, 8.2 хувийг салхин цэцэг, 7.4 хувийг тэмбүү, 6.2 хувийг цусан суулга, 6.2 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 5.0 хувийг трихомоназ, 4.8 хувийг заг хүйтэн, 3.1 хувийг улаан эсэргэнэ, 1.0 хувийг хоолны хордлого, 0.9 хувийг вируст хепатит өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

Хүснэгт 16. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 11 сард

	хэмжих нэгж	2015 он	2016 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	Хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	37533	37594	61	0.2
	10000 хүнд	290.8	282.7	- 8.1	
Вируст хепатит	бодит тоо	484	323	- 161	- 33.3
	10000 хүнд	3.8	2.4	- 1.4	
Цусан суулга	бодит тоо	2215	2320	105	4.7
	10000 хүнд	17.2	17.4	0.2	
Салхин цэцэг	бодит тоо	2887	3101	214	7.4
	10000 хүнд	22.7	23.3	0.6	
Гахай хавдар	бодит тоо	128	227	99	1.8 дах
	10000 хүнд	1.0	1.7	0.7	
Сальмонеллөз	бодит тоо	98	151	53	1.5 дах
	10000 хүнд	0.8	1.1	0.3	
Улаан эсэргэнэ	бодит тоо	519	1155	636	2.2 дах
	10000 хүнд	4.0	8.7	4.7	
Улаан бурхан	бодит тоо	19042	15962	- 3080	- 16.2
	10000 хүнд	147.5	120.0	- 27.5	
Хоолны хордлого	бодит тоо	367	373	6	1.6
	10000 хүнд	2.8	2.8	0.0	
Ёлом	бодит тоо	92	109	17	1.2 дах
	10000 хүнд	0.7	0.8	0.1	
Нярайн халдвар	бодит тоо	4	0	- 4	-
	10000 хүнд	0.0	0.0	0.0	
Гар хөл амны өвчин	бодит тоо	1124	4459	3335	4.0 дах
	10000 хүнд	8.7	33.5	24.8	
Тэмбүү	бодит тоо	3772	2790	- 982	- 26.0
	10000 хүнд	29.2	21.0	- 8.2	
Заг хүйтэн	бодит тоо	1884	1794	- 90	- 4.8
	10000 хүнд	14.6	13.5	- 1.1	
Трихомониаз	бодит тоо	1654	1896	242	1.2 дах
	10000 хүнд	12.8	14.3	1.5	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	2387	2317	- 70	- 2.9
	10000 хүнд	18.5	17.4	- 1.1	
ДОХ	бодит тоо	13	20	7	1.8 дах
	10000 хүнд	0.1	0.2	0.1	



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж температур 2016 оны 11-р сард дунджаар -13.7⁰C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс -2.8⁰C-аар, олон жилийн дундажтай харьцуулбал -2.7⁰C-аар тус тус хүйтэн байлаа. Энэ сард үнэмлэхүй их температур 6.7⁰C, үнэмлэхүй бага температур -31.5⁰C, хур тунадасны нийлбэр 18.4 мм, салхины үнэмлэхүй их хурд 12 м/секунд хүрчээ.

Хүснэгт 17. Агаарын бохирдолт, мг/м³

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хийсэн ажиглалтын тоо	Хамгийн их хэмжээ	Стандартаас давсан тохиолдол /тоо/	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO ₂	0.020	302	0.233	114	0.050
Азотын давхар исэл	NO ₂	0.040	298	0.143	157	0.055
Тоосжилт	PM ₁₀	0.100	312	0.776	220	0.188
	PM _{2.5}	0.050	167	0.517	147	0.151
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.000	595	10.732	1	1.970
Озон	O ₃	0.100	598	0.061	-	0.018

Мэдээллийн эх үүсвэр: Ус, цаг уур орчны хүрээлэн

Нийслэлийн хэмжээнд 2016 оны эхний 11 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 180 зөрчлийг илрүүлжээ.

Илрүүлсэн нийт зөрчлийн 23.3 хувийг газрын зөрчил, 16.1 хувийг геодези зураг зүй, кадастрийн зөрчил, 11.7 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 10.6 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 8.3 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 5.6 хувийг ойн зөрчил, 4.4 хувийг ангийн зөрчил, 20.0 хувийг бусад зөрчлүүд эзэлж байна.


Илрүүлсэн нийт зөрчилд 69.6 сая төгрөгийн торгууль ногдуулж, ойн зөрчлөөс 2.4 сая төгрөг, ангийн зөрчлөөс 0.3 сая төгрөгийн хураагдсан эд зүйлсийг улсын орлого болгож, нийт 72.3 сая төгрөгийг нийслэлийн төсөвт оруулжээ.

Хүснэгт 18. Байгаль орчны зөрчил, төрлөөр, эхний 11 сард

Илрүүлсэн зөрчил төрлөөр	2015 он			2016 он		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/
Ой	19	37	10.0	16	10	3.8
Ан, амьтан	9	19	4.2	13	8	1.9
Газрын	14	98	36.1	12	42	28.6
Ус	4	1	-	7	-	1.1
Ургамал, хөрсний бохирдол	6	11	0.8	12	15	3.5
Агаар, химийн хорт бодисын	27	147	3.1	12	21	5.0
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	18	34	9.9	20	19	6.6
Геодези зураг зүй, кадастр	8	138	9.8	13	29	1.5
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	5	12	15.4	7	1	7.7
Бусад	19	19	6.6	52	35	9.9
Бүгд	129	516	95.9	164	180	69.6


Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2016 оны 11-р сард Улаанбаатар хотын 13-р хороолол орчимд 25 удаа, Телевиз орчимд 23 удаа, Баруун 4 зам орчимд 20 удаа, 32-ын тойрог болон Хархорин зах орчимд тус бүр 19 удаа, Амгалан орчимд 16 удаа, Ургах наран хороолол орчимд 13 удаа, Толгойт болон 1-р хороолол орчимд тус бүр 11 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж Амгалан орчимд 25 удаа, Телевиз орчимд 24 удаа, Толгойт орчимд 20 удаа, 32-ын тойрог орчимд 16 удаа, Ургах наран хороолол орчимд 10 удаа, Баруун 4 зам орчимд 8 удаа, 13-р хороолол орчимд 7 удаа, Хархорин зах орчимд 4 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.



Зураг 24. Хүхэрлэг хийн агууламж, мг/м³



10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Телевиз болон 32-ын тойрог орчимд тус бүр 28 удаа, Толгойт орчимд 26 удаа, Хархорин зах орчимд 25 удаа, 1-р хороолол орчимд 22 удаа, Баруун 4 зам болон Амгалан орчимд тус бүр 19 удаа, Нисэх орчимд 18 удаа, 13-р хороолол орчимд 16 удаа, Ургах наран хороолол орчимд 10 удаа, Мишээл экспо төвийн орчимд 9 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Телевиз орчимд 30 удаа, Толгойт орчимд 28 удаа, Баруун 4 зам орчимд 26 удаа, Амгалан орчимд 24 удаа, Нисэх орчимд 23 удаа, 13-р хороолол орчимд 16 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Зураг 25. Азотын давхар ислийн агууламж, мг/м³



Зураг 26. Тоосны /PM₁₀/ агууламж, мг/м³Зураг 27. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м³

Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатор 2016 оны 11 дугаар сарын 9-10 ны өдөр Туул голын усны найрлагад хэмжилт хийсэн.

Туул-Зайсан харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хүлцэх хэм хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгчийн горим алдагдсан маш бохир, нитридийн нэгдэл 34 дахин, амоны азот 24.3 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 11.2 дахин, эрдэс фосфор 5.8 дахин хүлцэх хэм хэмжээнээс хэтэрч, Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 19. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, 11-р сард

	Стандарт хэмжээ	“Туул-Зайсан” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O ₂)	≥6	12.16		4.86	Горим алдагдсан
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ ₅)	≤ 3	2.0		33.5	11.2 дахин
Нитридийн нэгдэл (NO ₂)	≤ 0.02	0.001	хэвийн	0.68	34 дахин
Амоны азот (NH ₄)	≤0.5	0.06		12.14	24.3 дахин
Эрдэс фосфор (P)	≤0.1	0.002		0.579	5.8 дахин

*- Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2016 оны 11-р сарын танилцуулга

Хүснэгт 20. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, 11-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл - Экспо төв	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруу- дын ордон	Хархорин Зах	Ургах наран хороолол	Нисэх	Толгойт	Телевиз	Амгалан
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	-	0.037	0.014	0.040	0.058	0.018	0.029	0.040	0.019	0.096	0.118	0.081
	Хамгийн их	-	0.080	0.041	0.099	0.143	0.032	0.061	0.087	0.037	0.194	0.233	0.139
	XXX*-с давсан хувь	-	26.7	-	28.0	53.3	-	14.3	33.3	-	76.9	92.3	83.3
	Хэмжилтийн тоо	-	30	30	25	30	22	28	30	25	26	26	30
Азотын давхар Исэл NO ₂	Дундаж	-	0.096	0.041	0.095	0.056	0.022	0.055	0.050	0.025	0.054	0.058	0.051
	Хамгийн их	-	0.138	0.060	0.143	0.086	0.041	0.096	0.094	0.037	0.103	0.089	0.090
	XXX*-с давсан хувь	-	100.0	36.7	100.0	63.3	-	63.3	43.3	-	39.3	76.7	53.3
	Хэмжилтийн тоо	-	20	30	25	30	20	30	30	25	28	30	30
Нүүрс- төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	-	-	-	1.139	1.961	-	1.226	-	1.198	3.176	3.268	1.819
	Хамгийн их	-	-	-	3.550	8.013	-	3.588	-	3.163	10.732	9.881	5.352
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	1.2	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	-	78	87	-	90	-	76	84	90	90
Тоос PM10	Дундаж	0.099	0.157	0.207	0.143	0.258	-	0.225	0.091	0.151	0.327	0.266	0.148
	Хамгийн их	0.232	0.439	0.596	0.364	0.676	-	0.570	0.189	0.359	0.776	0.556	0.372
	XXX*-с давсан хувь	34.6	65.5	73.3	64.0	93.3	-	83.3	34.5	72.0	92.9	93.3	63.3
	Хэмжилтийн тоо	26	29	30	25	30	-	30	29	25	28	30	30
Тоос PM2.5	Дундаж	-	0.122	-	0.093	-	-	-	-	0.118	0.256	0.216	0.102
	Хамгийн их	-	0.343	-	0.290	-	-	-	-	0.299	0.517	0.498	0.239
	XXX*-с давсан хувь	-	86.7	-	66.7	-	-	-	-	92.0	100.0	100.0	80.0
	Хэмжилтийн тоо	-	30	-	24	-	-	-	-	25	28	30	30
Озон O ₃ **	Дундаж	-	-	-	0.012	0.010	-	-	0.034	0.011	0.013	0.018	0.026
	Хамгийн их	-	-	-	0.032	0.031	-	-	0.058	0.027	0.039	0.053	0.061
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	-	78	90	-	-	90	76	84	90	90

*- Хүлцэх хэм хэмжээ, **- CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар



ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ


2016 оны эхний 11 сард нийслэлийн хүн амд 31.2 сая.м³, аж ахуйн нэгж, байгууллагад 9.6 сая.м³ цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан нийт усны хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар буурсан байна.

Нийт борлуулсан усны 76.5 хувийг хүн амд, 23.5 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан ус эзэлж байна. Хүн амд түгээсэн цэвэр усны 96.1 хувь буюу 30.0 сая.м³ усыг төвлөрсөн шугамаар, 1.2 сая.м³ усыг ус түгээх байраар, 11.0 мян.м³ усыг тээврээр түгээсэн байна. Цэвэрлэх байгууламжаар 56.0 сая.м³ бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 40.7 сая.м³ бохир шингэнийг татан зайлуулсан байна.


Хүснэгт 21. Ус суваг ашиглалтын үйлчилгээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012 он XI сар	2013 он XI сар	2014 он XI сар	2015 он XI сар	2016 он XI сар	$\frac{2016}{2015} \%$
Шахсан ус	мян.м ³	49995.6	50438.4	49059.5	47875.5	47954.4	100.2
Борлуулсан ус	мян.м ³	39404.1	40824.1	41492.3	41280.3	40795.9	98.8
Хүн амд	мян.м ³	29373.4	29895.9	29853.8	30941.1	31192.5	100.8
ААНБ-д	мян.м ³	10030.7	10928.2	11638.5	10339.2	9603.4	92.9
Татан зайлуулсан бохир	мян.м ³	38839.6	39977.3	40427.1	40300.9	40743.9	101.1
Хүн амаас	мян.м ³	27875.1	27848.8	27677.0	28719.3	30106.5	104.8
ААНБ-аас	мян.м ³	10964.5	12128.5	12750.1	11581.6	10637.4	91.8
Ус борлуулалтын орлого	сая төг	13733.3	14657.2	18495.9	24179.2	23620.0	97.7
Хүн амаас	сая төг	8074.2	8463.4	10231.1	14177.2	14137.3	99.7
ААНБ-аас	сая төг	5659.1	6193.8	8264.8	10002.0	9482.7	94.8
Сувагжуулалтын орлого	сая төг	7679.6	8150.0	10598.3	14789.2	15820.3	107.0
Хүн амаас	сая төг	4102.9	4100.0	4757.8	6525.6	7350.7	112.6
ААНБ-аас	сая төг	3576.7	4050.0	5840.5	8263.6	8469.6	102.5

Зураг 28. Борлуулсан ус, сараар, мян.м³



Зураг 29. Татан зайлуулсан бохир, сараар, мян.м³






ГЭМТ ХЭРЭГ

2016 оны эхний 11 сард 16689 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1.5 хувь буюу 244 хэргээр өсчээ.

Гэмт хэргийн илрүүлэлт 61.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.0 пунктээр дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 6355 хүн гэмтэж осолдож, 307 хүн нас барж, төр ард иргэдэд 113.2 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 19.3 хувь буюу 21.8 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 34.3 хувийг хулгайн, 27.4 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 10.7 хувийг залилан, 6.7 хувийг танхайн, 5.2 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг тус тус эзэлж байна.

Зураг 30. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Хүснэгт 22. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр, эхний 11 сард

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2015 он	2016 он	Тоо	Хувь
Хүний амь	104	80	- 24	- 23.1
Хүчин	119	128	9	7.6
Дээрэм	422	353	- 69	- 16.4
Хулгай	5345	5717	372	7.0
Булаалт	173	148	- 25	- 14.5
Залилан	1593	1785	192	12.1
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	4345	4568	223	5.1
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	992	875	- 117	- 11.8
Бусдыг амиа хорлоход хүргэх	102	116	14	13.7
Ашиглах	178	184	6	3.4
Танхайрах	1157	1121	- 36	- 3.1
Бусад	1915	1614	- 301	- 15.7
БҮГД	16445	16689	244	1.5

2016 оны эхний 11 сард 45202 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 11.1 хувь буюу 5655 хүнээр буурсан байна.

Хүснэгт 23. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр, эхний 11 сард

дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2015 он	2016 он	Тоо	Хувь
Багануур	288	276	- 12	- 4.2
Багахангай	21	21	0	0
Баянгол	2680	2941	261	9.7
Баянзүрх	3934	3904	- 30	- 0.8
Налайх	396	460	64	16.2
Сонгинохайрхан	2967	2664	- 303	- 10.2
Сүхбаатар	2801	2702	- 99	- 3.5
Чингэлтэй	2084	2200	116	5.6
Хан-Уул	1274	1521	247	19.4
ДҮН	16445	16689	244	1.5

Хүснэгт 24. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2016 оны эхний 11 сард


дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс сэжигтнийг илрүүлж ял сонгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
Багануур	98	69	70.4
Багахангай	5	3	60.0
Баянгол	1454	948	65.2
Баянзүрх	2632	1456	55.3
Налайх	175	131	74.9
Сонгинохайрхан	1818	1223	67.3
Сүхбаатар	2007	1201	59.8
Чингэлтэй	1455	852	58.6
Хан-Уул	746	502	67.3
ДҮН	10390	6385	61.5

Хүснэгт 25. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 11 сард

дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2015 он	2016 он	2015 он	2016 он
Багануур	68	67	53	54
Багахангай	2	3	1	2
Баянгол	609	815	496	662
Баянзүрх	1396	1431	1212	1221
Налайх	88	141	76	131
Сонгинохайрхан	1165	894	1063	815
Сүхбаатар	1048	1071	813	891
Чингэлтэй	644	859	560	804
Хан-Уул	325	436	304	398
ДҮН	5345	5717	4578	4978

2016 оны эхний 11 сард хүндэвтэр хэрэг 7285, онц хүнд хэрэг 300, хүнд хэрэг 815 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.1-17.3 хувиар буурч, харин хөнгөн хэрэг 8289 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өсчээ.

Зураг 31. Гэмт хэргийн тоо, ангиллаар



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 13847 болж, 2015 оны мөн үеэс 6.3 хувь буюу 816 хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 16.5 хувь буюу 2280 нь согтуугаар үйлдсэн, 12.3 хувь буюу 1699 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 6.7 хувь буюу 932 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 4.5 хувь буюу 617 нь хүүхэд, 17.1 хувь буюу 2373 нь эмэгтэйчүүд байна.



ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2016 оны эхний 11 сард 448 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар өссөн байна. Нийт гамшигт хүчтэй шороон шуурга 1, Аадар бороо, үер 1, хүний үйл ажиллагаатай холбоотой 446 осол бүртгэгдсэн байна. Хүний үйл ажиллагаатай холбоотой осолд тэсрэх дэлбэрэх бодис 1 осол, химийн бодисын 14 осол, сүм галт хэрэгслийн 1 осол, бичил уурхай, нурангины 1 осол, усны 27 осол, барилгын 1 осол, бусад төрлийн 401 осол бүртгэгджээ. Гамшгийн улмаас 38 хүн амь насаа алдаж, 335 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 4.9 сая төгрөг зарцуулжээ.

Нийслэл хотод 2016 оны эхний 11 сард ахуйн 2297 гал түймэр гарсан байна. Ахуйн гал түймэр өмнөх оны мөн үеэс 17.5 хувиар буурсан байна. Гал түймрийн улмаас 15 хүн (үүнээс, хүүхэд 2) амь насаа алдаж, 21 хүн (үүнээс, хүүхэд 9) түлэгдэж гэмтжээ. Гал түймрийн аюулаас 469 хүн, 43 мал, амьтан, 852 байшин барилга, 3.3 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна.


Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал цахилгаанаас 380, санамсаргүй байдлаас 1690, шалтгаан тогтоогдоогүй 121, бусад шалтгаанаар 106 гал түймэр гарчээ. Гал түймэрт 845 гэр, орон сууц, 201 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 129 машин техник, малын 288 хашаа, саравч, бусад төрлийн 834 объект өртсөн байна. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 1375, төрийн өмчийн 530, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 392 объект өртөж, нийт 3.5 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Хүснэгт 26. Гал түймрийн тоо, дүүргээр


Дүүрэг	2013 он	2014 он	2015 он	2016 он	$\frac{2016}{2015}$ %
Бүгд	2556	2784	3089	2297	82.5
Багануур	29	31	43	37	119.3
Багахангай	3	6	10	7	116.6
Баянгол	413	408	416	382	93.6
Баянзүрх	568	669	734	561	83.8
Налайх	88	114	77	87	76.3
Сонгинохайрхан	498	543	676	497	91.5
Сүхбаатар	353	436	444	262	60.1
Хан-Уул	231	262	300	214	81.7
Чингэлтэй	373	315	389	250	79.4

Гал түймэрт 845 гэр, орон сууц, 201 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 129 машин техник, малын 288 хашаа, саравч, бусад төрлийн 834 объект өртсөн байна. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 1375, төрийн өмчийн 530, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 392 объект өртөж, нийт 3.5 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Зураг 32. Гал түймэр, шалтгаанаар



Зураг 33. Гал түймэр, байршлаар



Нийслэлийн Онцгой байдлын газраас 2016 оны эхний 11 сард 184 барилгын зураг төсөл, мөн ашиглалтад хүлээн авч буй 442 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 6661 айл өрх, 9765 объектод үзлэг шалгалт хийж, 49589 галын зөрчил илрүүлж, 109 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 1954 заавал биелүүлэх албан шаардлага, 3375 мэдэгдэл хүргүүлж, 56.1 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.



НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ

Нийслэлийн төсвийн орлого ба улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн дүн 2016 оны эхний 11 сард 767.8 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 56.6 тэрбум төгрөгөөр буюу 6.9 хувиар дутуу бүрдсэн байна. Төсвийн нийт орлогын 55.3 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 6.8 хувийг татварын бус орлого, 37.9 хөрөнгийн болон тусламжийн орлого, улсын төсөв

болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна.

Татварын орлого 424.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 23.8 тэрбум төгрөгөөр буюу 5.3 хувиар, татварын бус орлого 52.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 17.1 тэрбум төгрөгөөр буюу 24.6 хувиар тус тус дутуу бүрдсэн байна.

Орлогын албан татвар төлөвлөснөөс 18.2 тэрбум төгрөгөөр, бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 4.8 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрджээ.

Хүснэгт 27. Нийслэлийн төсвийн орлого, дүүргээр, сая төгрөг

	Төсвийн орлого			Үүнээс:					
	Бүгд	ТБ %	Зөрүү	Татварын орлого			Татварын бус орлого		
				Бүгд	ТБ %	Зөрүү	Бүгд	ТБ %	Зөрүү
Багануур	10318.4	77.6	-2985.8	564.5	93.5	-39.4	419.4	120.3	70.8
Багахангай	2463.5	89.1	-301.9	68.4	86.6	-10.6	92.0	114.5	11.6
Баянгол	55555.2	94.2	-3399.5	11853.3	83.0	-2427.3	682.5	60.1	-452.2
Баянзүрх	71734.9	96.7	-2465.9	14325.7	87.5	-2055.6	350.8	484.3	278.3
Налайх	12811.4	97.8	-290.1	653.9	90.8	-66.2	283.6	148.0	92.0
Сонгинохайрхан	61114.6	96.5	-2197.4	5218.2	84.8	-938.2	674.1	51.3	-640.5
Сүхбаатар	65285.0	85.4	-11152.5	12656.2	100.0	0.0	11131.9	54.2	-9419.8
Хан-Уул	47276.3	96.3	-1834.4	14466.2	93.0	-1085.2	2091.6	93.5	-145.1
Чингэлтэй	58977.7	111.8	6207.4	28605.0	128.8	6387.6	888.6	182.6	402.0
Нийслэлийн шууд	382259.9	86.4	-38170.1	336486.3	93.3	-23582.5	35974.4	83.7	-7339.7
Дүн	767796.8	93.1	-56590.2	424897.9	94.7	-23817.5	52588.8	75.4	-17142.5

Хүснэгт 28. Нийслэлийн төсвийн зарлага, дүүргээр, сая төгрөг

	Орлогын дүн	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	зөрүү	
Багануур	10318.4	13511.9	12872.2	95.3	132.7	-2553.8
Багахангай	2463.5	5238.3	4564.7	87.1	-673.6	-2101.2
Баянгол	55555.2	60133.5	54522.3	90.7	-5611.3	1032.9
Баянзүрх	71734.9	74224.4	68533.8	92.3	-5690.6	3201.1
Налайх	12811.4	16647.8	15691.4	94.3	-956.4	-2880.0
Сонгинохайрхан	61114.6	66148.6	64269.1	97.2	-1879.4	-3154.5
Сүхбаатар	65285.0	72808.9	58833.0	80.8	-13975.8	6452.0
Хан-Уул	47276.3	50255.9	41439.0	82.5	-8816.9	5837.3
Чингэлтэй	58977.7	60078.0	51504.7	85.7	-8573.3	7473.1
Нийслэлийн шууд	382259.9	596808.0	527361.0	88.4	-69447.0	-145101.2
Нийт дүн	767796.8	1015855.3	899591.3	88.6	-116264.0	-131794.5

Хүснэгт 29. Нийслэлийн төсвийн орлого, 2016 оны эхний 11 сард, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	ТБ %	Зөрүү, сая.төг
Нийт орлого	824387.0	767796.8	93.1	-56590.2
1. Татварын орлого	448715.4	424897.9	94.7	-23817.5
Орлогын албан татвар	307111.3	288906.0	94.1	-18205.3
Хувь хүний орлогын албан татвар	307111.3	288906.0	94.1	-18205.3
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын	283162.9	269276.7	95.1	-13886.3
Үйл ажиллагааны орлогын	25025.1	21194.2	84.7	-3830.9
Хөрөнгө борлуулсны орлогын	6398.9	5807.5	90.8	-591.3
Шууд бус орлого	17896.9	18019.5	90.8	-591.3
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-25415.0	-25408.1	100.7	122.6
Орлогыг тодорхойлох боломжгүй иргэний	42.5	16.2	100.0	6.9
Хөрөнгийн албан татвар	59427.6	58566.3	38.1	-26.3
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	34313.1	37083.1	108.1	2769.9
Бууны албан татвар	414.5	266.3	64.3	-148.2
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	24700.0	21216.9	85.9	-3483.1
Бусад татвар, төлбөр, хураамж	82176.4	77425.6	94.2	-4750.9
Улсын тэмдэгийн хураамж	26248.1	31995.8	121.9	5747.8
Газрын төлбөр	36600.0	28702.6	78.4	-7897.4
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	155.8	79.2	50.8	-76.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12018.4	11157.2	92.8	-861.2
Усны төлбөр	3207.2	1957.8	61.0	-1249.4
Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны	28.8	45.6	158.2	16.8
Нийслэл хотын албан татвар	3600.0	3167.3	88.0	-432.7
Бусад татвар, хураамж	318.1	320.1	100.6	2.0
2. Татварын бус орлого	69731.2	52588.8	75.4	-17142.4
Нийтлэг татварын бус орлого	69731.2	52588.8	75.4	-17142.4
Хувьцааны ногдол ашиг	950.0	620.8	65.3	-329.2
Хүүгийн орлого	13958.5	4592.3	32.9	-9366.2
Торгуулийн орлого	25308.4	20007.0	79.1	-5301.4
Төсөвт байгууллагын өөрийн орлого	9470.7	7906.7	83.5	-1564.0
Түрээсийн орлого	1370.0	1381.9	100.9	11.9
Бусад нэр заагдаагүй орлого	18673.6	18080.1	96.8	-593.6
3. Хөрөнгийн орлого	12300.0	198.3	1.6	-12101.7
4. Тусламжийн орлого	2063.7	4248.3	205.9	2184.5
5. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	291576.7	285863.6	98.0	-5713.1
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	276917.6	275812.2	99.6	-1105.4
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	14659.1	10051.4	68.6	-4607.7

2016 оны эхний 11 сард орон нутгийн төсөв болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 88.6 хувийг буюу 899.6 тэрбум

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2016 оны 11-р сарын танилцуул

төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 11.4 хувийг буюу 116.3 тэрбум төгрөгийг төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна. Төсвийн нийт зарлагын 21.4 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 2.3 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 6.4 хувийг татаас, 23.1 хувийг үрсгал шилжүүлэг, 27.0 хувийг хөрөнгийн зардал, 19.8 хувийг бараа ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 30. Өглөгтэй дүүргүүд, сая төгрөг

	11-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	11-р сарын эцсийн үлдэгдэл
Багануур	131.5	44.7	64.4	111.7
Багахангай	13.3	1.4	6.5	8.3
Баянгол	649.8	315.6	98.5	866.9
Баянзүрх	456.3	0.0	0.0	456.3
Налайх	185.7	21.4	104.0	103.2
Сонгинохайрхан	1043.8	98.5	325.2	817.2
Сүхбаатар	151.5	212.7	205.7	158.6
Хан-Уул	213.4	32.1	165.0	80.5
Чингэлтэй	43.0	0.0	0.0	43.0
Нийслэлийн шууд	658.0	36.4	270.7	423.7
Нийт	3546.3	762.9	1239.9	3069.3

Нийслэлийн төсөв болон тусгай зориулалтын шил-жүүлгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд 11-р сарын эхэнд 3546.3 сая төгрөгийн өглөгтэй байсан ба тайлант хугацаанд шинээр 762.9 сая төгрөгийн өглөг үүсч, тухайн сард 1239.9 сая төгрөгийн өглөгийг төлж барагдуулан, сарын эцэст 3069.3 сая төгрөгийн өглөгтэй үлдсэн байна.

Хүснэгт 31. Авлагатай дүүргүүд, сая төгрөг

	11-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн авлага	Тухайн сард барагдуулсан	11-р сарын эцсийн үлдэгдэл
Багануур	5.1	0.0	1.6	3.6
Багахангай	3.2	0.0	0.2	2.9
Баянгол	46.4	28.9	15.0	60.3
Баянзүрх	15.4	0.0	0.0	15.4
Сонгинохайрхан	5.4	0.0	0.6	4.8
Сүхбаатар	5.8	0.0	0.0	5.8
Хан-Уул	160.1	0.0	0.0	160.1
Нийслэлийн шууд	5237.3	20.0	2.0	5255.3
Нийт	5478.7	48.9	19.4	5508.2

Төсөвт байгууллагууд сарын эхэнд 5478.7 сая төгрөгийн авлагатай байснаас тайлант хугацаанд шинээр 48.9 сая төгрөгийн авлага үүсч, тухайн сард 19.4 сая төгрөгийн авлагыг барагдуулан, сарын эцэст 5508.2 сая төгрөгийн авлагатай үлджээ.